



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Тайлант онд хэрэгжиж дуусгахаар гэрээ байгуулсан УТХО-ын төсөл, арга хэмжээний 22.7 хувь нь, ОНХО-ын төсөл, арга хэмжээний 77.6 хувь нь бүрэн хэрэгжсэн байна.

АУДИТЫН СЭДЭВ: УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2023/02-НА-СТА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	
	Утас: 70363040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
2023 он	Аудитын менежер	Б.Батмөнх
	Утас: 70363036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор	С.Баасансүрэн
	Утас: 70363036	Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
	Аудитор Ж.Цогт	Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	3
Дүрслэлийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	5
А бүлэг: УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд нь “Алсын хараа - 2050”-ийн зорилтуудыг жигд хангаагүй байна.	6
А.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улс, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулалгүйгээр төлөвлөсөн байна.	6
А.2 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан байна.	7
Б бүлэг: 2022 онд хэрэгжиж дуусах төсөл, арга хэмжээний 77.3 хувь нь гэрээний хугацаандаа ашиглалтад ороогүй байна.	12
Б.1 Үнэлгээний хороонд томилогдсон гишүүд нь “Үнэлгээний хороо”-ны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг гаргаагүй байна.	12
Б.2 Тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний дөнгөж 22.7 хувь нь бүрэн хэрэгжиж, 77.3 хувь нь дутуу хэрэгжсэн байна.	13
Б.3 “Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасадны засвар /Сэлэнгэ, Сайхан сум/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байхад 85.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.	15
Б.4 Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын алба болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд огт хяналт шалгалт хийгээгүй байна.	16
Б.5 УТХО-ын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу ашиглалтад хүлээн авч, холбогдох баримт, материалаар баталгаажуулсан байна.	17
В бүлэг: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн болон Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцүүлэн төлөвлөөгүйгээс нийт төсөл арга хэмжээний 17.0 хувь нь огт хэрэгжээгүй байна.	18
В.1 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	18
В.2 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан нийт төсөл, арга хэмжээний 5.4 хувь нь дутуу, 17.0 хувь нь огт хэрэгжээгүй байна.	20
Илрүүлсэн зөрчил	25
Дүгнэлт	25
Зөвлөмж	26
Ирүүлсэн санал, тайлбар	28
Төрийн аудитын газрын тайлбар	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОАЖ	Байгаль орчин, аялал жуулчлал
БХБ	Барилга, хот байгуулалт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУ	Боловсрол, шинжлэх ухаан
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЯ	Сангийн яам
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үзүүлэлт
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХЗДХ	Хууль зүй, дотоод хэрэг
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХНХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМ	Эрүүл мэнд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Хүснэгтийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан төсөл, арга хэмжээ	8
Хүснэгт 2	Санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тохируулан хуваарилаагүй төсөл, арга хэмжээ	9
Хүснэгт 3	Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	19
Хүснэгт 4	Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалт	22
Хүснэгт 5	Өмнөх оноос шилжсэн бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ	25
Хүснэгт 6	Батлагдсан төсөвт өртгийг нэмэгдүүлж гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээ	26
Хүснэгт 7	Тендерийн хэмнэлтийг нэмэлт гэрээ байгуулан олгосон төсөл, арга хэмжээ	27

Дүрслэлийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1-2	Батлагдсан төсөл, арга хэмжээ	19
Дүрслэл 3-4	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт	22

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх, ➤ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх, ➤ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийг аймгийн ТЕЗ, ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ, “Сэлэнгэ барилга захирал” ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнууд, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны болон санхүүжилтийн баримт материалуудыг хамруулав.

Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын тулгуур зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аймаг, сумдын ЗДТГ, аймгийн ГХБХБГ, ОНӨГ, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, худалдан авалт, санхүүжилттэй холбоотой баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон улсын төсвийн санхүүжилтээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэх, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд: • Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, • Төсвийн тухай хууль, • Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, • Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Барилгын тухай хууль, • Авто замын тухай хууль, • Эрчим хүчний тухай хууль, • “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, • УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, • Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, • Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, • Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,

	• Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”, • Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”, • Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2021 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг хөгжүүлэх 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”, • Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт нар 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 4 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.
Ерөнхий мэдээлэл:	2022 оны Төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймагт 8 яаманд харьяалагдах нийт 69,678.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас аймгийн Засаг даргад 10,263.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. Эрх нь шилжиж ирсэн он дамжин хэрэгжих 24,799.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээнээс гадна 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр 2022 онд шинээр эхлэх 10,263.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн бөгөөд 7 төсөл, арга хэмжээнд нийт 9,365.1 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. 2022 онд аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 10,473.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 149 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар эцэслэн баталсан байна. Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,329.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 төсөл, арга хэмжээ, 12 сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,144.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 121 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

Бүлэг А

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн үү?

УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд нь “Алсын хараа - 2050”-ийн зорилтуудыг жигд хангаагүй байна.

А.1 Төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан уу?

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улс, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулалгүйгээр төлөвлөсөн байна.

А.1.1 УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар 9 үндсэн зорилго бүхий “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

А.1.2 2022 оны Төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймагт 8 яаманд харьяалагдах нийт 69,678.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас аймгийн Засаг даргад нийт 10,263.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав./

А.1.3 Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн дээрх 9 төсөл, арга хэмжээ нь “Алсын хараа- 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил”, “Амьдралын чанар ба дундаж давхарга”, “Засаглал”, “Ногоон хөгжил”, “Амар тайван, аюулгүй нийгэм”, “Бүс, орон нутгийн хөгжил” гэсэн үндсэн 6 зорилготой нийцүүлэн төлөвлөсөн байна.

А.1.4 Харин бусад “Үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг” зэрэг зорилгууд орхигдож, эдгээр чиглэлээр аймаг, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөөгүй байна.

А.1.5 Эрх шилжүүлсэн дээрх 9 төсөл, арга хэмжээнээс УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 7-д “Амар тайван, аюулгүй нийгэм” гэсэн зорилтод тусгагдсан 200.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/” 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн бол уг хөтөлбөрт тусгагдаагүй нийт 10,063.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

А.1.6 Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.1.5-д “Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж арга хэмжээг хэрэгжүүлэх”, 2.5.2-т “Агаар, ус, хөрсний бохирдлыг багасгаж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж,

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн *амьдрах ээлтэй орчин бүрдүүлэх*” гэсэн 2 зорилтод тусгагдсан нийт 1,250.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах 3 төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- 800.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Ерөнхий боловсролын сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/”,
- 250.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум/”
- 200.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Сэлэнгэ, Мандал сум/ ”

A.1.7 Хөрөнгө оруулалтыг улс, аймгийн хөгжлийн дунд хугацааны бодлогуудтай уялдуулан төлөвлөх нь орон нутгийн хөгжилд эерэг өөрчлөлтийг бий болгож байна. Тухайлбал:

- “Ерөнхий боловсролын сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээр аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 34 сургууль лабораторийн тоног төхөөрөмжөөр хангагдаж, хүүхдийн сурах орчин нөхцөл сайжирсан,
- “Ногоон байгууламжийн усалгааны систем”, “Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт” төсөл, арга хэмжээнүүд хэрэгжсэнээр Сүхбаатар, Мандал сумдын оршин суугчдын агаар, ус, хөрсний бохирдлыг багасгах, эрүүл, аюулгүй орчинд тав тухтай амьдрах нөхцөл боломж тодорхой хэмжээгээр бүрдсэн байна.

A.1.8 Хэдийгээр 2022 онд УТХО-аар Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэхээр баталж, эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ нь “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн ерөнхий зорилгуудын дийлэнхийг хангаж байгаа боловч “Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” болон улс, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцээгүй байна.

A.2 Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү?

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан байна.

A.2.1 УТХО-аар 2022 онд хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн, нийт 10,263.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ / шинж чанарын хувьд барилга байгууламж 6, их засвар 2, тоног төхөөрөмж 1/ нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой байна.

A.2.2 Аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 28.2¹-т заасны дагуу УТХО-ын 2022 оны төлөвлөгөөнд тусгуулахаар Шадар сайд, Ерөнхий сайд болон ХЗДХЯ, БШУЯ, БХБЯ, СЯ, ХНХЯ, ЭМЯ-дад нийт 58,374.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн 88 төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлснээс 950.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1. Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан төсөл, арга хэмжээ

/сая төгрөгөөр/

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Аймгийн ТЕЗ-аас санал хүргүүлсэн, төсөл, арга хэмжээ		Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналаас УТХО-ын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан		2022 онд хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн нийт төсөл, арга хэмжээ	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шадар сайд	1	340.0				
2	Ерөнхий сайд	1	4,350.0				
3	Хууль зүй, дотоод хэргийн сайд	1	182.0			1	200.0
4	Сангийн сайд	42	32,947.4				
5	Барилга, хот байгуулалтын сайд	5	1,777.8	1	500.0	4	6,500.0
6	Боловсрол, шинжлэх ухааны сайд	21	8,045.1			1	800.0
7	Эрүүл мэндийн сайд	7	8,384.0	1	450.0	1	513.0
8	Соёлын сайд	3	575.5				
9	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	3	1,772.6				
10	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд					1	2,000.0
11	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд					1	250.0
Нийт		88	58,374.4	2	950.0	9	10,263.0

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-аас яамдад хүргүүлсэн санал, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль

A.2.3 Аймгийн Засаг даргаас хүргүүлсэн саналын 98.4 хувь нь төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаа нь аймаг, орон нутгийн хэрэгцээ шаардлага, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ач холбогдлыг нарийвчлан эрэмбэлээгүй, хэт олон тооны санал хүргүүлдгээс шалтгаалсан гэж үзэж байна.

A.2.4 Аймагт эр шилжүүлсэн 9 төсөл арга хэмжээнээс 10,063.0 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээ нь 2022-2023 он дамжин хэрэгжихээр батлагдсан боловч санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилаагүйгээс 2022 оны санхүүжилт 3,403.9 сая төгрөгөөр дутуу батлагдсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5² дахь заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2. Санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тохируулан хуваарилаагүй төсөл, арга хэмжээ

/сая төгрөгөөр/

² ... хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана: 29.3.5 шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Батлагдсан		Төсвийн тухай хуулиар 2022 онд хуваарилбал зохих санхүүжилт	Зөрүү
			Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих		
1	VI.1.18	Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2022	2023	250.0	50.0	125.0	75.0
2	XII.1.111	Жишиг сум /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2022	2023	4,000.0	879.0	2,000.0	1,121.0
3	XII.1.125.6	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Сэлэнгэ, Мандал сум/	2022	2023	200.0	36.0	100.0	64.0
4	XII.2.18	Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасадны засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	2022	2023	1,800.0	100.0	900.0	800.0
5	XII.2.34	Цэвэрлэх байгууламжийн их засвар, шинэчлэл /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2022	2023	500.0	100.0	250.0	150.0
6	XIII.1.3.17	Ерөнхий боловсролын сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/	2022	2023	800.0	160.0	400.0	240.0
7	XIX.1.72	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 15 ор /Сэлэнгэ, Цагааннуур сум/	2022	2023	513.0	102.6	256.5	153.9
8	XVII.1.21	Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн лабораторийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2022	2023	2,000.0	200.0	1,000.0	800.0
Нийт дүн					10,063.0	1,627.6	5,031.5	3,403.9

A.2.5 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд нь жигд хуваарилахгүй байгаа нь сонгон шалгаруулалт амжилтгүй болох, улмаар төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

A.2.6 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүдийг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3. УТХО-оор 2022 онд шинээр эхэлсэн төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлага хангасан байдал

/сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар баталсан эсэх	Зураг төсөв боловсруулсан эсэх		Газрын зөвшөөрөл олгосон огноо	Техникийн нөхцөл олгосон огноо				Магадлалын ерөнхий дүгнэлт	
				Төсөв батлахын өмнө	Төсөв батлагдсаны дараа		Цахилгаан хангамж	Дулаан хангамж	Ус хангамж, ариутгах татуурга	Холбоо дохиолол	Огноо	Хянагдсан төсвийн дүн
1	Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	250.0	Батлаагүй		2022.02.10	Шаардлагагүй	-	-	2022.02.18	-	2022.08.30	249.7
2	Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	200.0	Батлаагүй		2022.02.26	2011.12.13	2022.04.07	2022.02.17	2022.09.09	2022.02.21	-	-
3	Жишиг сум /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	4,000.0	2022.02.22		2022.11.09	Шаардлагагүй	2022.08.11	2022.08.12	2022.08.13	-	Түлхүүр гардуулах нөхцөлтэй	
4	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Сэлэнгэ, Мандал сум/	200.0	Батлаагүй		-	Шаардлагагүй	Шаардлагагүй				-	-
5	Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасадны засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	1,800.0	Батлаагүй	2021.12.25	-	Шаардлагагүй	Шаардлагагүй				2022.04.18	1,800.0
6	Цэвэрлэх байгууламжийн их засвар, шинэчлэл /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	500.0	2022.03.25		2022.03.01	Шаардлагагүй	-	-	-	-	-	-
7	Ерөнхий боловсролын сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/	800.0	Шаардлагагүй		2022.01.07-нд үнийн судалгаа хийсэн	Шаардлагагүй	Шаардлагагүй				Шаардлагагүй	
8	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 15 ор /Сэлэнгэ, Цагааннуур сум/	513.0	Батлаагүй	2018.08.27	-	Шаардлагагүй	2018.09.13	2018.09.12	-	-	2019.01.02	512.7
9	Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн лабораторийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2,000.0	Батлаагүй		2022.03.17	2022.03.09	-	-	-	-	-	-
Нийт дүн		10,263.0										

Дээрх хүснэгтээс харахад:

- Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3.4³, 3.5⁴ дахь заалттай нийцээгүй нийт 9,463.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээнээс 4,963.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй,
- Эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөл / цахилгаан, дулаан, ус хангамж болон холбоо дохиоллын техникийн нөхцөл / - аваагүй 2,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ,
- Төсвийн тухай хуулийн 29.4⁵, Барилгын тухай хуулийн 24.1.1⁶ дэх заалтуудтай нийцэхгүй нийт 3,150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсанаас хойш батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгүүлсэн,
- Барилгын тухай хуулийн 25.2⁷, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын 6.3⁸ дахь заалтуудтай нийцэхгүй нийт 2,900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ / нийт 9,463.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний зураг, төсөвт магадлал хийлгэхээс / -ний зураг, төсвийг магадлал хийлгэж, баталгаажуулаагүй байна.

А.2.7 УТХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг, төсөвт магадлал хийлгэж баталгаажуулаагүй нь төсөл арга хэмжээний явц, хэрэгжилт удаашрах, гүйцэтгэлийн чанарт муугаар нөлөөлөх, гэрээний хугацаанд хэрэгжих боломжгүй байдалд хүрэх зэрэг эрсдэлийг дагуулж байна.

Бүлэг Б

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцэж байна уу?

2022 онд хэрэгжиж дуусах төсөл, арга хэмжээний 77.3 хувь нь гэрээний хугацаандаа ашиглалтад ороогүй байна.

Б.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан уу?

Үнэлгээний хороонд томилогдсон гишүүд нь “Үнэлгээний хороо”-ны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг гаргаагүй байна.

³ Архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймаг, нийслэлийн ерөнхий архитектур батална.

⁴ Захиалагч барилга байгууламжийн байршлыг тогтоосон шийдвэр, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж батална.

⁵ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁶ Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 24.1.1. батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх.

⁷ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

⁸ Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан зураг төсөлд заавал магадлал хийнэ.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Б.1.1 УТХО-аар хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргад эрх шилжсэн, шинээр эхлэх 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар сонгон шалгаруулахаар “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./*

Б.1.2 УТХО-аар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.1⁹-д заасны дагуу 2022 оны 05 дугаар сарын 01-ээс өмнө аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар, түүнээс хойш аймгийн Засаг даргын захирамж / 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр ТБОНӨХБАҮХА тухай хуульд өөрчлөлт орсон бөгөөд хуулийн 45.2-т “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад дор дурдсан этгээд захиалагч байна: 45.2.2-т аймаг, нийслэлийн Засаг дарга нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд” / -аар 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Б.1.3 Үнэлгээний хороонд томилогдсон 47 гишүүн /давхардсан тоогоор/ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1¹⁰-д заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан бол “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”-ийг гаргаагүй нь Сангийн сайдын 2015 оны 330 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Б.1.4 Төлөвлөсөн хугацаанд “Үнэлгээний хороо”-г байгуулж, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулсан боловч оролцогч санал ирүүлээгүй болон ирүүлсэн санал нь шаардлага хангаагүй зэргээс шалтгаалж 4 төсөл, арга хэмжээний НТШ-ийг 2 удаа зарлаж, тендерт 60-90 хоног зарцуулсан байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./*

Б.1.5 Тайлант онд 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар зохион байгуулсан 1-3 удаагийн тендер шалгаруулалтад тус бүр 1-4 оролцогч оролцсон бөгөөд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу бүх худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд мэдээлсэн байна.

Б.1.6 Аймгийн Онцгой комиссын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 12 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн БХБ-ын сайдаас эрх шилжүүлсэн 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүн амд үзүүлэх усан хангамж, ариутгах татуургын үйлчилгээний үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх /Сэлэнгэ, Сүхбаатар сум/” төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсэн байна.

Б.2 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй байна уу?

Тайлант онд хэрэгжүүлж дуусгаахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний дөнгөж 22.7 хувь нь бүрэн хэрэгжиж, 77.3 хувь нь дутуу хэрэгжсэн байна.

⁹ Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.

¹⁰ Энэ хуулийн 23.8-д заасан журмын дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

Б.2.1 2021-2022 он дамжин хэрэгжих 24,799.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээнээс гадна 2022 онд шинээр эхлэх 10,263.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ /2022 онд 3, 2023 онд 4 төсөл, арга хэмжээг дуусахаар төлөвлөж гэрээ байгуулсан бол 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгараагүй тул гэрээ байгуулаагүй байна./ -г хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн бөгөөд 7 төсөл, арга хэмжээнд нийт 9,365.1 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Б.2.2 Өмнөх оноос он дамжин хэрэгжих 19, шинээр эхлэх 9 зэрэг нийт 28 төсөл, арга хэмжээнээс барилга байгууламжийн 13, их засварын 9 зэрэг нийт 22 төсөл, арга хэмжээ /2023 онд он дамжин хэрэгжих 4, гүйцэтгэгч шалгараагүйгээс гэрээ байгуулаагүй 2/ -г 2022 онд хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав /

Б.2.3 Дээрх 22 төсөл, арга хэмжээний 22.7 хувь буюу нийт 1,270.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ /барилга байгууламж 2, их засвар 3/ нь барилгын норм дүрэм, батлагдсан зураг, төсвийн дагуу гэрээний хугацаанд бүрэн хэрэгжсэнийг улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав /

Б.2.4 Харин тайлант онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 77.3 хувь буюу 26,645.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав /

/Залуучуудын хөгжлийн ордны барилга
Сэлэнгэ, Сайхан сум/

/Ахмадын төвийн барилга Сэлэнгэ,
Мандал сум/



Б.2.5 Техникийн нөхцөлийг бүрэн аваагүй, зураг, төсвийг урьдчилан хийлгээгүй, магадлалаар баталгаажуулаагүй зэрэг төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг УТХО-ын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн болон барилгын материалын үнэ огцом өссөнөөс зураг, төсвийг дахин хийж, магадлалаар баталгаажуулах ажилд цаг хугацаа ихээхэн шаардлагатай болсон зэргээс голлон шалтгаалж гэрээт ажлууд хугацаандаа бүрэн хэрэгжээгүй байна.

Б.2.6 Гэрээт хугацаанд хэрэгжиж дуусаагүй 17 төсөл, арга хэмжээнээс 15,263.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлэхээр гэрээний хугацааг сунгасан бол 8,630.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 6 төсөл, арга хэмжээний гэрээт хугацааг сунгаагүй байгаа нь төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлийг дагуулж байна. Үүнд:

- 5,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орхон голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/”,

- 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхэд, залуучуудын парк /Сэлэнгэ, Сүхбаатар сум/”,
- 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Засаг даргын Тамгын газрын барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/”,
- 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Халуун усны барилга /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/”,
- 280.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар, 5 ор /Сэлэнгэ, Жавхлант сум/”,
- 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/”

Б.2.7 2020 онд эхэлсэн боловч гүйцэтгэгч “Эрдэнэт констрактив” ХХК, “Оргил таун констракшн” ХХК-иуд нь гэрээний үүргээ биелүүлээгүйгээс дараах 3 төсөл арга хэмжээ / 2022 оны Төсвийн хуулийн өөрчлөлтөөр 3 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 69.9 сая төгрөгийг олгохоор төлөвлөсөн/ хэрэгжиж дуусаагүй бөйгөн Үүнд:

- 181.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Спорт, сургалтын цогцолборын барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум/”,
- 180.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр цэцэрлэг/”,
- 238.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон, Янзагахан цэцэрлэг/”

Б.2.8 Дээрх 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бодит байдлаас илүү үнэлж, санхүүжилтийг олгосон байсан бөгөөд гэрээт ажлууд дутуу хийгдсэнээс шалтгаалж байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа алдагдсан байдалтай байсныг өмнөх аудитад тодорхой дурдсан бөгөөд уг байдал нь өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй байна.

Б.2.9 Уг 3 их засварын ажлыг хэрэгжүүлэгч 2 компани тайлант онд гэрээт ажлыг үргэлжлүүлээгүй, хэрэгжүүлэхээс зайлсхийсэн нөхцөл байдалтай байхад захиалагчийн зүгээс Сангийн яамны “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлснээс бусдаар хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэргээр гэрээт ажлыг гүйцэтгүүлэх талаар ямар ч арга хэмжээ аваагүй байна.

Б.3 Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгосон уу ?

“Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасадны засвар /Сэлэнгэ, Сайхан сум/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байхад 85.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Б.3.1 2022 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний явцын санхүүжилтийг хяналт хэрэгжүүлсэн эрх бүхий албан тушаалтнуудын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, ашиглагч байгууллагын тодорхойлолт, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн олгосон байна.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Б.3.2 Улсын комиссын актаар ашиглалтад оруулсан 4 төсөл, арга хэмжээний эцсийн санхүүжилтийг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан *“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”*-ын 4.1.29¹¹, 4.1.30¹²-д заасны дагуу барилга байгууламж, их засварын ажлын хяналтын хуудас, гүйцэтгэлийн төсвийг үндэслэн *“Гэрээ дүгнэх маягт”*-аар баталгаажуулж олгосон байна. / Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав /

Б.3.3 Харин улсын комиссын актаар ашиглалтад оруулсан 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Нийтийн эзэмшлийн байруудын гэрэлтүүлэг /Сэлэнгэ, Сүхбаатар сум/”* төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч “Гандирын тал” ХХК нь гүйцэтгэлийн баримт материалыг бүрдүүлж өгөөгүйгээс сүүлийн санхүүжилт 31.5 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна.

Б.3.4 Улсын комиссын актаар ашиглалтад оруулсан 5 төсөл, арга хэмжээний 2-т нь чанарын баталгааны асуудлыг тусгаагүй бол 3-т нь чанарын баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тооцож, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулахаар гэрээнд тусгасан байна.

Б.3.5 Гэрээний дагуу тайлант онд улсын комиссын актаар ашиглалтад хүлээлгэн өгсөн 2 төсөл, арга хэмжээний чанарын баталгаа 32.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан бол 1 төсөл арга хэмжээний 21.5 сая төгрөгийг байршуулаагүй байна.

Б.3.6 Тайлант онд гэрээ байгуулж, он дамжин хэрэгжих 1,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасадны засвар /Сэлэнгэ, Сайхан сум/”* төсөл, арга хэмжээ нь 6 хувийн гүйцэтгэлтэй байхад 85.0 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний Тусгай нөхцөлийн 48 дахь “... ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрэхэд 1 дэх санхүүжилтийг гэрээний дүнгийн 30 хувийн санхүүжилтийг олгоно ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Б.3.7 Дээрхээс бусад өмнөх оноос дамжин хэрэгжих болон шинээр эхэлсэн төсөл, арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэлийг үндэслэж, гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу явцын буюу 1, 2 дахь санхүүжилтийг 20-70 хувиар тооцож, гүйцэтгэгч компаниудад олгосон байна. / Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав /

Б.3.8 2022 оны жилийн эцсийн байдлаар хугацаанд нь ашиглалтад хүлээлгэн өгөөгүй болон он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилт нийт 2,527.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна.

Б.3.9 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Засаг даргын Тамгын газрын барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/”* төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон 100.0 сая төгрөгийн хэмнэлтээр дулаан, цэвэр усны шугам, бохирын тоног төхөөрөмж тавих нэмэлт ажлын гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна. байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.3 дахь *“Хөрөнгө оруулалтын*

¹¹ Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу бөглөн баталгаажуулж ирүүлнэ.

¹² Төслийн эцсийн санхүүжилтийг ирүүлэхэд гэрээг дүгнэсэн байх ёстой бөгөөд хавсралт №12-т заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд *төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх*” гэсэн заалтыг зөрчсөн байна

Б.4 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй байна уу ?

Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын алба болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд огт хяналт шалгалт хийгээгүй байна.

Б.4.1 Тайлант онд аймгийн ГХБХБГ-тай байгуулсан гэрээний үндсэн дээр өмнөх оноос шилжиж ирсэн 19, тайлант онд шинээр эхэлсэн 6 / *тоног төхөөрөмж нийлүүлэх 1, гэрээ байгуулаагүй 2 төсөл арга хэмжээ хасагдсан* / зэрэг нийт 25 барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээнд Барилгын тухай хуулийн 37.1.4¹³, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.12¹⁴-т заасны дагуу захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлсэн байна.

Б.4.2 Аймгийн ГХБХБГ-ын холбогдох албан тушаалтнууд нь Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.9¹⁵, 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2¹⁶-т заасны дагуу үе шат бүрд хяналт хийж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж, тайлангаар баталгаажуулсан байна.

Б.4.3 Барилгын тухай хуулийн 37.1.5¹⁷, “Барилга захиалагчийн дүрэм”-3.1.4¹⁸-т заасны дагуу тайлант онд хэрэгжүүлсэн дээрх төсөл, арга хэмжээний үе шат бүрд зураг, төсөв зохиогчийн хяналтыг гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч компаниудаар гүйцэтгүүлж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулан, “Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт”-ээр баталгаажуулсан байна.

Б.4.4 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “*Ерөнхий боловсролын сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/*” төсөл, арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргаар ахлуулсан ажлын хэсэг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

¹³ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах.

¹⁴ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

¹⁵ Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

¹⁶ Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ.

¹⁷ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

¹⁸ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Б.4.5 Харин аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын алба болох Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт шалгалт хийж, хэрэгжилт, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.

Б.5 Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан уу?

УТХО-ын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу ашиглалтад хүлээн авч, холбогдох баримт, материалаар баталгаажуулсан байна.

Б.5.1 Тайлант онд дусгахаар гэрээ байгуулсан 22 төсөл, арга хэмжээний 5 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан бөгөөд гүйцэтгэлийг “Гэрээ дүгнэх маягт”-аар баталгаажуулсан байна. / Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав /

Б.5.2 Улсын комиссын актаар хүлээн авсан дээрх 5 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд болох Алтанбулаг сумын ЗДТГ, “Эрч” СӨХ, “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ, Шаамар сумын Дулаанхаан тосгоны ЭМТ зэрэг байгууллагууд бүртгэл, тайланд бүрэн тусгасан байна.

Б.5.3 Харин 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн эзэмшлийн байруудын гэрэлтүүлэг /Сэлэнгэ, Сүхбаатар сум/” төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт,...*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Бүлэг В

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй байна уу?

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн болон Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцүүлэн төлөвлөөгүйгээс нийт төсөл арга хэмжээний 17.0 хувь нь огт хэрэгжээгүй байна.

В.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү?

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

В.1.1 Аймаг, сумдын ИТХ-аар өмнөх оноос дамжин хэрэгжих 8, 2022 онд шинээр хэрэгжих 141 зэрэг нийт 10,473.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 149 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эцэслэн баталсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 4-т харуулав/ Үүнд:

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,329.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 төсөл, арга хэмжээ,
- 12 сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,144.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 121 төсөл, арга хэмжээ,

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Хүснэгт № 3 / сая төгрөг /

№	Сумдын нэр	Баталсан төсөл, арга хэмжээ	
		Тоо	Төсөвт өртөг
1	Баруунбүрэн сум	1	13.0
2	Ерөө сум	20	1,546.9
3	Зүүнбүрэн сум	15	239.5
4	Мандал сум	17	1,826.4
5	Орхон сум	8	399.7
6	Сайхан сум	1	90.0
7	Сант сум	3	22.1
8	Сүхбаатар сум	19	664.8
9	Түшиг сум	1	40.0
10	Хүдэр сум	24	1,020.5
11	Цагааннуур сум	4	76.4
12	Шаамар сум	8	205.4
	Нийт дүн	121	6,144.7

Эх сурвалж: 2022 оны сумдын ИТХ-ын тогтоол.


В.1.2 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан нийт 141 төсөл, арга хэмжээг дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн төлөвлөсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 4-т харуулав/

В.1.3 2022 онд аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр баталсан 141 төсөл, арга хэмжээний 27.7 хувь буюу 39 төсөл, арга хэмжээ нь дэд

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн бүтцийн салбарт, 19.9 хувь буюу 28 төсөл, арга хэмжээ нь боловсролын салбарт, 9.2 хувь буюу 13 төсөл, арга хэмжээ нь эрүүл мэндийн салбарт, 5.7 хувь буюу 8 төсөл, арга хэмжээ нь байгаль, орчны салбарт зарцуулагдсан бол 37.6 хувь буюу 53 төсөл, арга хэмжээ нь бусад салбаруудад чиглэсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 4-т харуулав/

В.1.4 Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 141 төсөл, арга хэмжээг шинж чанарын хувьд авч үзэхэд 39.0 хувь буюу 55 нь тоног, төхөөрөмж худалдан авах, 36.9 хувь буюу 52 нь их засвар, 14.9 хувь буюу 21 нь барилга байгууламж, 7.1 хувь буюу 10 нь зураг төсөв боловсруулах, гаалийн албан татвар төлөх 2, нийтийг хамарсан ажил хийх 1 төсөл, арга хэмжээ байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 4-т харуулав/

Дүрслэл №1 Батлагдсан төсөл, арга хэмжээ /хувиар/



Дүрслэл №2 Батлагдсан төсөл, арга хэмжээ /төсөвт өртгөөр, сая төгрөгөөр/



В.1.5 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд гаалийн албан татвар зэрэг урсгал зардлын шинж чанартай, тухайн байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлж болох хэт жижиглэсэн буюу 20.0 сая төгрөгөөс доош өртөг бүхий төсөл арга хэмжээ /автомашин, техник, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах/ болон ОНХС-ийн төсөвт тусган хэрэгжүүлэхээр зохицуулагдсан “Зураг, төсөв хийлгэх” ажлыг тусган хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 4-т харуулав/

В.1.6 Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар албан байгууллага, сумдаас ирүүлсэн саналыг эрэмбэлж, үнэлэх ажил огт хийгдээгүй байна.

В.1.7 Аймаг, сумдын ИТХ-аар төсөвлөлтийн шаардлага хангаагүй дараах төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган баталж байгаа нь ажлын явц, гүйцэтгэл удаашрах, чанарт муугаар нөлөөлөх, санхүүжилт дутагдах эрсдэлийг үүсгэж байна. Үүнд:

- Зураг төсөвт магадлал хийлгэж баталгаажуулаагүй 4,643.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21,
- Зураг, төсвийг урьдчилан хийгээгүй 4,981.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 45

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- *Техникийн тодорхойлолтыг боловсруулж, үнийн тооцоо судалгаа хийгээгүй, холбогдох техникийн нөхцөлийг иж бүрэн аваагүй зэрэг 757.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 гэх мэт. /Дэлгэрэнгүйг Судалгааг 4-т харуулав/*

В.1.8 Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтад орох гарах хаалга, иргэний эзэмшилд бүртгэгдэх хашаа барих ажлуудыг тусгасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 4.1.24¹⁹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3²⁰ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- *Гудамжны хашаа хөтөлбөр /Зүүнбүрэн сум/ -10.0 сая төгрөг,*
- *Сумын орох, гарах хаалгыг засварлах /Мандал сум/ - 4.0 сая төгрөг,*
- *1-р багт хашаа төсөл, үргэлжлүүлэх /Сүхбаатар сум/ - 20.0 сая төгрөг,*
- *Хүдэр хаалганы тохижилт /Хүдэр сум/ -19.0 сая төгрөг,*

В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан нийт төсөл, арга хэмжээний 5.4 хувь нь дутуу, 17.0 хувь нь огт хэрэгжээгүй байна.

В.2.1 Аймгийн Засаг даргын 2021 оны А/393 дугаар захирамжаар 2022 онд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 1,791.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг сумдын Засаг дарга нарт шилжүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт № 4 / сая төгрөг /

№	Сумд	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Алтанбулаг	Сургуулийн дээврийн засвар	56.5
2	Баруунбүрэн	Сургуулийн дээврийн засвар	100.0
3	Зүүнбүрэн	Лингафоны танхим байгуулах	50.0
4		Биохимийн аппарат, цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат, иммунологийн аппарат авах	39.0
5		Цэцэрлэгийн дээврийн засвар	30.0
6	Мандал	Сумын байрнуудын дээвэр, фасад засвар	540.0
7		4-р сургуулийн дээврийн засвар	140.0
8	Орхон	Гематологийн анализатор авах	15.0
9		Эмнэлгийн дээврийн засвар	44.0
10	Сайхан	Багийн байрны засвар	28.0
11	Сүхбаатар	6-р сургуулийн сантехник, худгийн засвар	60.0

¹⁹ “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ.”

²⁰ Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно

12	Түшиг	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн их засвар	269.0
13	Хушаат	Ахуйн үйлчилгээний их засвар	100.0
14	Цагааннуур	Биологийн кабинет байгуулах	20.0
15		Спорт цогцолборын их засвар	300.0

В.2.2 Аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар тайлант онд шинээр хэрэгжүүлэх 10,164.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 141 төсөл арга хэмжээнээс 138 төсөл, арга хэмжээний / 3 нь урсгал зардлыг санхүүжүүлэх / худалдан авах ажиллагааг дараах аргуудаар зохион байгуулахаар “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгасан байна. Үүнд:

- 5,952.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар,
- 1,884.9 сая төгрөгийн 37 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар,
- 803.3 сая төгрөгийн 64 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар,
- 1,361.3 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар гэх мэт. /Дэлгэрэнгүйг Судалгаа 4-т харуулав./

В.2.3 Үүнээс 8,792.7 сая төгрөгийн өртөг бүхий 116 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас:

- 5,952.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар,
- 1,554.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,
- 641.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар сонгон шалгаруулж,
- 644.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 4-т харуулав/

В.2.4 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 28 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны “Үнэлгээний хороо”-г тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бол сумдын хувьд “Ажлын хэсэг”-ийг 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

В.2.5 Шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэснээс бусад 8,148.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 63 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг цахим системд мэдээлсэн бөгөөд тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан жишиг баримт, бичгийн дагуу боловсруулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 4-т харуулав/


В.2.6 Сүхбаатар сум нь 19.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн тээврийн үйлчилгээний бага оврын автобус худалдан авах” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтод 2012 оноос хойш үйлдвэрлэгдэж, 2020 он болон түүнээс хойш импортлогдсон автомашин нийлүүлэхээр тусгасан боловч 2011 онд үйлдвэрлэгдэж, 2014 онд импортлогдсон автомашин санал болгосон, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх чиглэлээр үйл

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн ажиллагаа явуулдаг “Мандалын Хясаа” ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, хэрэгжүүлсэн байна.

В.2.7 Аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар нийт 9,883.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 147 төсөл, арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөснөөс: / 590.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжих/

- 7,506.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 114 төсөл, арга хэмжээ бүрэн,
- 1,139.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж,
- 1,237.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №3-4



Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтууд

В.2.8 Барилгын материалын үнэ нэмэгдсэн, худалдан авах ажиллагааг оройтуулж зохион байгуулсан зэргээс шалтгаалан 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн аймгийн хөрөнгө оруулалтын 1, Ерөө сумын 1, Мандал сумын 5, Сүхбаатар сумын 1 зэрэг нийт 1,139.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна.

В.2.9 Аймаг, сумд нь төсвийн тодотголоор төсөл, арга хэмжээг нэмж баталснаас худалдан авах ажиллагааны хугацаа оройтсон, огт зарлаагүй, худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч шалгараагүй, захиалагч гэрээгээ цуцалсан зэрэг шалтгаанаар тайлант онд хэрэгжих 1,237.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 25 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 4-т харуулав/

В.2.10 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Хот тохижилтын гэрэлтүүлэг солигч пишктэй машин /Сүхбаатар сум/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Баян булагт тал” ХХК-тай 64.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааг гүйцэтгүүлсэн байна.

В.2.11 Гэвч чанарын баталгааны 1 жилийн хугацаа дуусаагүй байхад уг тээврийн хэрэгсэл нь 3 удаа эвдэрч, сэлбэг хэрэгслийн зардал гаргасан боловч ашиглах боломжгүй байна.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

В.2.12 Иймд тээврийн хэрэгслийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, гүйцэтгэгч байгууллагаар засварлуулах, чанарын баталгааны тодорхойлолтоо биелүүлээгүй нөхцөлд гэрээг цуцлан, тээврийн хэрэгслийг буцаах нь зүйтэй юм.

В.2.13 Шаамар сумын ИТХ-ын 2022 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан 5.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий *“Дулаанхан Захирагчийн албаны зураг төсөв”* төсөл, арга хэмжээг *“Шаамар 6-гийн 4 замын уулзварт баригдах эрүүл мэндийн түргэн тусламжийн байрны барилгын зураг төсөв”* гэж нэршлийг өөрчлөн гүйцэтгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 33.2.6²¹ дахь заалтыг зөрчсөн байна

В.2.14 Аймаг, сумдууд бүрэн хэрэгжсэн 114 төсөл арга хэмжээнд 7,367.9 сая төгрөг, дутуу хэрэгжсэн 8 төсөл арга хэмжээнд 1,331.3 сая төгрөг зэрэг нийт 8,699.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 27.0 сая төгрөгийг аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд байршуулан, сумдын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 1,088.2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

В.2.15 Дараах сумдууд гүйцэтгэгчид нийт 3.9 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна Үүнд:

- Сүхбаатар сум 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“4-р баг 16 айлын орон сууцны гадна засвар”-ын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнийн дүнгээс 1.6 сая төгрөгийг илүү,*
- Хүдэр сум 2 төсөл арга хэмжээний батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн 2.1 сая төгрөг,
- Шаамар сум 1 төсөл, арга хэмжээний батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн 0.2 сая төгрөг гэх мэт.

В.2.16 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь *“Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх”* гэсэн заалтыг хэрэгжүүлэлгүйгээр 3 төсөл, арга хэмжээний тендерийн хэмнэлт 55.1 сая төгрөгийг нэмэлт гэрээ байгууж, зарцуулсан байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын гадна фасад, дотор их засвар” /аймгийн хөрөнгө оруулалт/-44.3 сая төгрөг,
- Орхон сумын эмнэлгийн дээвэр засвар” /аймгийн хөрөнгө оруулалт/-2.3 сая төгрөг,
- Бугант тосгонд орон сууцнуудын подволын цэвэр, дулааны шугам шинэчлэл” /Ерөө сумын төсвийн хөрөнгө оруулалт/-8.5 сая төгрөг.

В.2.17 Сумдууд нь гэрээний биелэлт, үр дүнг үнэлсэн *“Гэрээ дүгнэх маягт”*-гүйгээр нийт 498.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээний, *“Хүлээн авсан комиссын акт”*-гүйгээр 174.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээнд 163.8 сая төгрөгийн эцсийн санхүүжилтийг олгосон нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан *“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл,*

²¹ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.29²², 4.1.30²³, 4.3.3²⁴, 4.3.4²⁵-т заасныг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 4-т харуулав/

В.2.18 2022 онд хэрэгжсэн нийт 5,645.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээнд Барилгын тухай хуулийн 37.1.4²⁶, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.12²⁷-т заасны дагуу “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь явцын болон техникийн хяналтыг ажлын үе шат бүрд хэрэгжүүлж, зөрчлийг арилгуулан, хяналтын тайлангаар баталгаажуулсан байна.

В.2.19 БХБ-ын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 83 дугаар тушаалын 2.1.3 дахь хэсэгт “Барилгын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-д заасан аймгийн ГХБХБГ-ын чиг үүрэгтэй давхардуулан орон нутагт Барилгын захиалагчийн алба байгуулах болон аймгийн Засаг даргын Тамгын газарт гэрээгээр хяналтын инженер авч ажиллуулахгүй байх, байгуулсан бол холбогдох хууль тогтоомжийн хүрээн татан буулгаж шийдвэрлэх” гэж заасны дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан боловч хэрэгжилтийг хангаагүй байна.

В.2.20 Төсөвт өртөг багатай, автомашин, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах нийт 1,474.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 57 төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг аймаг, сумдын ЗДТГ-ууд хэрэгжүүлсэн бол сумдууд 94.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна.

В.2.21 Зураг, төсөв зохиогчийн төсөл, арга хэмжээний үе шат бүрд хэрэгжүүлж, зөрчил дутагдлыг арилгуулан, зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлтээр баталгаажуулсан байна.

В.2.22 Харин аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт шалгалт хийгээгүй, хэрэгжилт, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.

²² Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу бөглөн баталгаажуулж ирүүлнэ.

²³ Төслийн эцсийн санхүүжилтийг ирүүлэхэд гэрээг дүгнэсэн байх ёстой бөгөөд хавсралт №12-т заасан “Гэрээ дүгнэх маяг”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

²⁴ Их засварын ажлыг хийж дуусаад комисс ажиллан хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хангана.

²⁵ Захиалагч худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулан тухайн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, хавсралт №11-д заасан маягтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

²⁶ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах.

²⁷ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

В.2.23 Дараах сумдууд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжиж дууссан 20 төсөл, арга хэмжээний нийт 1,680.2 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудын бүртгэл, тайланд бүрэн тусгаагүй байна. Үүнд:

- *Ерөө сум 561.5 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ,*
- *Зүүнбүрэн сум 10.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ,*
- *Мандал сум 670.8 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ,*
- *Орхон сум 10.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ,*
- *Сүхбаатар сум 252.5 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ,*
- *Хүдэр сум 135.2 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ,*
- *Шаамар сум 40.2 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ.*

В.2.24 Захиалагч байгууллагууд нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилд хүрэх зорилтот түвшин, үр дүнг тооцоогүй байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **11,547.6** сая төгрөгийн зөрчил илэрч, 3.9 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 11,553.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв. / Зөрчлийн нэгтгэлийг Хавсралт 1-д дэлгэрэнгүй харуулав./

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргаас УТХО-ын 2022 оны төлөвлөгөөнд тусгуулахаар хэт олон буюу нийт 58,374.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 88 төсөл, арга хэмжээний санал хүргүүлснээс 950.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ нь төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан байна.
- УТХО-ын төсөл, арга хэмжээг улс, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулалгүйгээр төлөвлөсөн байна.
- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
- УТХО-аар хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний дөнгөж 22.7 хувь нь бүрэн хэрэгжиж, 77.3 хувь нь дутуу хэрэгжсэн байна.
- ОНХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээний 77.6 хувь нь бүрэн, 5.4 хувь нь дутуу хэрэгжсэн бол 17.0 хувь нь огт хэрэгжээгүй байна.
- УТХО-ын 100.0 сая төгрөгийн, ОНХО-ын 55.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлтийг нэмэлт ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, зарцуулсан байна.
- 3 сум гүйцэтгэгчид нийт 3.9 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна.
- Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийж, үр дүнг үнэлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д:

- Холбогдох хууль, хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь үнэлж, эрэмбэлсэн төсөл арга хэмжээг УТХО-ын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлэх, ОНХО-ын төлөвлөгөөнд тусган батлуулахаар өргөн мэдүүлэх.
- ОНХО-ын төлөвлөгөөнд хэт жижиглэсэн, байгууллагын урсгал төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой, хөрөнгийн шинж чанартай бус төсөл, арга хэмжээг тусган хэрэгжүүлж буй зөрчлийг арилгаж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх.
- Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийг хууль, хяналтын байгууллагуудад шилжүүлэх болон бусад үр нөлөө бүхий арга хэмжээ авсаны үндсэн дээр дутуу буюу огт хэрэгжээгүй төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, ашиглалтад оруулах.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн тендерийн хэмнэлтээр нэмэлт ажлын гэрээ байгуулж, зарцуулахгүй байх.
- Төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийн зардлыг ОНХС-ийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байх.
- БХБ-ын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 83 дугаар тушаалын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, ГХБХБГ-ын чиг үүрэгтэй давхардуулан байгуулсан “Барилга захиалагч ОНӨААТҮГ”-ыг татан буулгах арга хэмжээ авах.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, үнэлэлт дүгнэлт өгөх.

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Октябрь-д:

- “Үнэлгээний хороо, “Ажлын хэсэг”-т томилогдсон гишүүдийн үнэлгээний хороонд ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг бүрэн гаргуулж, гарын үсгээр баталгаажуулж, архивлах.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг бүртгэл тайланд бүрэн тусгуулж байх.

Сумдын Засаг дарга нарт:

- Сумын төсвийн хөрөнгө оруулалтад Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон төсөвлөлтийн шаардлага хангасан, урсгал зардлын шинж чанартай бус, орон нутгийн чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг батлуулахаар өргөн мэдүүлэх.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн


- Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй гэрээний хугацаанд ашиглалтад оруулаагүй төсөл, арга хэмжээнүүдийг ашиглалтад оруулах арга хэмжээ авах.
- Гүйцэтгэгчийн санхүүжилтийг гэрээний дүнгээр шилжүүлж байх, тендерийн хэмнэлтээр нэмэлт ажил хийлгэх гэрээ байгуулахгүй байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

С.БААСАНСҮРЭН

Ж.ЦОГТ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ИРҮҮЛСЭН
САНАЛ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-2223


2023.04.20 № 01/592

танай _____-ны № _____

Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.



ДЛХАГВАДОРЖ

C:\user\albanbichig2023\tom toot A4

430600128

Хавсралт 1

Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Сумын нэр	УТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт									Нийт
		Аймаг	Сумд								
			Баруунбүрэн	Ерөө	Зүүнбүрэн	Мандал	Орхон	Сүхбаатар	Хүдэр	Шаамар	
Зураг, төсвийн даалгавар боловсруулаагүй	4,963.0										4,963.0
Зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн		2,603.5	13.0	914.5	20.0	250.0	205.5	517.6	327.8	130.0	4,981.9
Үнийн тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй	+	106.0		20.0	141.4		30.0	83.0	304.4	67.0	751.8
Зураг, төсөвт магадлал хийлгэж баталгаажуулаагүй	500.0			+		+	+	+	+		500.0
Техникийн нөхцөлийг иж бүрэн аваагүй	+			+			+				+
Иргэний эзэмшилд бүртгэлтэй хашааг солих ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн								+			+
Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглогдсон төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн					+	+		+	+		+
Техникийн тодорхойлолтод нийцээгүй санал ирүүлсэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.								+			+
Төсөл, арга хэмжээний нэршлийг өөрчлөн гүйцэтгэсэн										5.4	5.4
Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнийн дүнгээс илүү дүнгээр санхүүжилт олгосон								1.6			1.6
Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлж, санхүүжилтийг олгосон									2.1	0.2	2.3
Төндөрийн хэмнэлтээр нэмэлт гэрээ байгуулан санхүүжилт олгосон	100.0	44.3		8.5			2.3				155.1
Баталгаат хугацааны барьцааг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй	21.5										21.5
Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 30 хувьд хүрээгүй байхад санхүүжилтийг олгосон.	85.0										85.0
"Гэрээ дүгнэх маяг"-аар үнэлэлгүйгээр эцсийн санхүүжилтийг олгосон					+		+	+	+	+	+
Чанарын баталгаат хугацаа дуусаагүй байхад 3 удаа эвдэрсэн, бүрэн бус ажиллагаатай тээврийн хэрэгслийг хүлээн авсан.		+									+
"Хүлээн авсан комиссын акт" үйлдэлгүйгээр санхүүжилтийг олгосон.				+			+		+	+	+
Хэрэгжиж дууссан хөрөнгийг холбогдох байгууллагуудын бүртгэл, тайланд бүрэн тусгаагүй	80.0	+			+	+	+	+	+	+	80.0
Нийт дүн	5,749.5	2,753.8	13.0	943.0	161.4	250.0	237.8	602.2	634.3	202.6	11,547.6

Зарим төсөл, арга хэмжээний зөрчлийн дүнгээс давхардлыг хасаж тооцсон болно. Давхардсан зөрчлийг "+" тэмдгээр тэмдэглэсэн.